



ХӨВСГӨЛ АЙМГИЙН
БАЯНЗҮРХ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 08 сарын 30 өдөр

Дугаар А/121

Алтрага

Үнэлгээ тогтоох ажлын хэсэг
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргааны нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дүгээр зүйлийн 66.1, Онц байдлын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1, 10.2 дахь хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тоом 3 дугаар багийн нутаг Хижимтэд өвөлждөг Чулуунбаатарын Мөнхжаргалын өвлийн орон сууцны байшин 2024 оны 08 дугаар сарын 29-ний өдөр шатсан тул хохирлын үнэлгээг тогтоох ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:	Э.Ганзориг	(Тоом багийн Засаг дарга)
Гишүүд:	Ц.Хишигбаяр	(Нягтлан бодогч)
	Б.Мөнхбат	(Бэлтэс багийн Засаг дарга)
	Н.Галбадрах	(Тамгын газрын жолооч)
Нарийн бичгийн дарга:	Н.Долгормаа	(Байгаль хамгаалагч)

2.Хохирлын үнэлгээг бодитоор тогтоож холбогдох байгууллагуудад материалыг хүргүүлж ажиллахыг Ажлын хэсэгт үүрэг болгосугай.

3.Энэхүү захирамжийн биелэлтэд хяналт тавьж нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Тамгын газрын даргын албан үүргийг хавсран гүйцэтгэгч (А.Дэлгэрмаа)-д даалгасугай.

ДАРГА

Г.ОДСЭР